



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 1/573

Мөрөн сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, газар эзэмшигч хуулийн этгээд “Осбимо” ХХК (РД:4129849)-ийн ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/613 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалтаар “Осбимо” ХХК (РД:4129849)-д “Албан контор”-ын зориулалтаар эзэмшүүлсэн Мөрөн сумын 8 дугаар баг Даваадорж-2 215 тоотод байршилтай 6712008751 нэгж талбарын дугаартай 2605 м² газрын зориулалтыг өөрчилж, “Үйлчилгээтэй орон сууц”-ын зориулалттай болгон үлдсэн 19 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/613 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалтын 5 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч хуулийн этгээд “Осбимо” ХХК (РД:4129849)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ